2.0 Нийтлэг асуултууд

2.0 Нийтлэг асуултууд

1. Хичээлийн батлагдсан дүнг хэрхэн засах вэ?

Батлагдсан **хичээлийн дүнг** сургалтын менежерийн эрхээр цуцлах үйлдэл хийгдсэний дараа засах боломжтой.

Сургалтын менежер хичээлийн дүн цонхоор **хичээл** эсвэл **суралцагчийн нэр** мэдээлэл дээр дарж орж суралцагч, хичээлийг нь сонгож **Дүн цуцлах** товч дарсанаар уг хичээлийн дүнг засварлах боломжтой байна.

Анхаарах зүйлс: Зөвхөн боловсролын түвшинд засах боломжтой гэдэг нь Бага боловсрол , Суурь боловсролын түвшинг суралцаж төгссөн суралцагчийн дүнг засах боломжгүйг анхаарна уу.

Жишээ нь:

а. 6-р ангийн суралцагчийн 1-5 ангийн хичээлийн дүнг засах боломжгүй.

б. 9-р ангийн суралцагчийн 6-8-р ангийн хичээлийн дүнг засах боломжтой.

2. Хичээлийн дүн шилжиж ирсэн суралцагчийн дүн харагдаж байна. Иймээс энэ суралцагчийн дүн шивэхгүй байх нь зөв үү?

Идэвхтэй хичээлийн жил суралцагч шинээр шилжиж ирсэн үед шилжиж ирсэн дүн **Дүнгийн мэдээлэл** дээр харагдаж байгаа боловч уг суралцагчийн дүнг заавал Боловсролын түвшинд шивж оруулах шаардлагатай. Учир нь сургуулийн хэв шинжээс шалтгаалан судлагдахуун, хичээлийн нэрсийн жагсаалт өөр байгаа тул заавал шивж оруулсанаар хичээлийн дүн оруулах боломжтой.

2.1 Хичээлийн дүн бүртгэх ажиллагаа

2.1 Хичээлийн дүн бүртгэх ажиллагаа

Тухайн суралцагчийн суралцаж байгаа анги болон өмнөх ангиудад судалсан хичээлүүдийн жилийн эцсийн дүн, үнэлгээг бүртгэх үйл ажиллагааг энэ хэсэгт гүйцэтгэж болно.

Хичээлийн дүн бүртгэх ажиллагааг 2 хэлбэрээр гүйцэтгэж болно.

1. Хичээлээр: Тухайн нэг хичээлийг сонгож ангийн бүх хүүхдийн дүнг нэг цонхноос бүртгэж болно.

2. Суралцагчаар: Тухайн нэг суралцагчийг сонгож судалсан бүх хичээлийг нэг цонхноос бүртгэж болно.

1. Ангийн багш нь сурагчдын дүнг хичээл тус бүрээр нэмнэ. Суралцагчийн дүн нь “Бүртгэсэн” төлөвт шилжинэ. Бүртгэсэн дүнгийн мэдээллээ Сургалтын менежертээ илгээж баталгаажуулах шаардлагатай. Илгээгдсэн дүн нь “Хянагдаж байгаа” төлөвт шилжинэ. “Хянагдаж байгаа” төлөвтэй дүнг хасах боломжгүй байна.

2. Менежер анги бүлгийг сонгож суралцагчдын дүнгийн жагсаалтыг шалгана.

3. Менежер “Хянагдаж байгаа” төлөвтэй сурагчийн дүнг хянана.

3.1 Менежер Буруу эсвэл алдаатай гэж үзвэл суралцагчийн хичээлийн дүнг цуцалж болно. Дүн нь “Цуцлагдсан” төлөвт шилжинэ.

3.2 Менежер Дүнг хянаад зөвшөөрч байвал Баталгаажуулалт хийнэ.

4. Ангийн багш цуцлагдсан дүнг хянаж, өөрчлөлт оруулаад батлуулахаар дахин илгээж болно.

Төгсөх ангийн хувьд анхаарах нь:

- Заавал болон сонгон судлах хичээлийн дүнг бүлгийн сурагч бүрээр бүртгэсэн байх шаардлагатай.
- Батлагдсан дүн нь төгсөх ангийн суралцагчдын хувьд судлагдахууны дүн бодоход ашиглагдана.

Бага:
- 5-р ангид судалсан хичээлийн дүнг шинээр бүртгэх
- 1, 2, 3, 4-р ангид судалсан хичээлийн дүнг нягтлах, дутуу бол нөхөж бүртгэх

Суурь:
- 9-р ангид судалсан хичээлийн дүнг шинээр бүртгэх
- 6, 7, 8-р ангид судалсан хичээлийн дүнг нягтлах, дутуу бол нөхөж бүртгэх

Бүрэн дунд:
12-р ангид судалсан хичээлийн дүнг шинээр бүртгэх
10, 11-р ангид судалсан хичээлийн дүнг нягтлах, дутуу бол нөхөж бүртгэх

Хэрэглэгчийн эрх - Хийх үйлдлүүд

Хичээлийн дүнг оруулах хэсэгт Анги удирдсан багш болон Сургалтын менежерүүд дараах үйлдэлийг хийх боломжтой.

Анхаарах зүйлс

- Тухайн ангид судалсан байх хөтөлбөрт тусгагдсан хичээлүүдийг бүрэн эсэхийг шалгах.
- Ангийн бүх суралцагчийн төлөв **Идэвхтэй**, баталгаажуулалтын төлөв **Батлагдсан** байх.

2.2. Дүнгийн нэгтгэл /Хичээлээр/

2.2. Дүнгийн нэгтгэл /хичээлээр/

Зөвхөн хичээлийн нэр дээр дарж орсоноор хичээлийн дүн бүртгэх боломжтой.

Тухайн нэг хичээлийг сонгож ангийн бүх суралцагчдын дүнг нэг цонхноос бүртгэж болно.



Алхам	Үйл явц	Тайлбар
1.	Хэрэглэгчийн эрх	Хичээлийн дүн бүртгэх эрхтэй ангийн багш болон сургалтын менежер системд нэвтрэн орно. Анхаарах зүйлс: Дараах 2, 3, 4, 5-р алхамыг зөвхөн өөрийн хариуцаж буй ангийг сонгож дүн бүртгэж оруулна уу.
2.	Хичээлийн хөтөлбөр сонгох	• Бага боловсролын өдрийн хөтөлбөр • Суурь боловсролын өдрийн хөтөлбөр • Бүрэн дунд боловсролын өдрийн хөтөлбөр
3.	Анги сонгох	• Бага боловсрол /1,2,3,4,5-р анги/ • Суурь боловсрол /6,7,8,9 -р анги/ • Бүрэн дунд боловсрол /10,11,12-р анги/
4.	Бүлэг	Анги сонгоход үүсгэгдсэн бүлэг сонголтоор гарч ирнэ
5.	Хөтөлбөрийн төрөл	Уг тушаал нь хөтөлбөр, бүлэг, анги сонгоход автоматаар харагдана. Жнь: 12-р анги А/311-2+А/275-3+А/61 дугаар бүхий тушаалуудыг дагаж мөрдөж байгаа. Анхаарах зүйлс: Тухайн анги бүлэгт хамаарах зөв хөтөлбөрийн төрлийг сонгосноор суралцагчдийн жагсаалт гарна.
6.	Хичээлийн нэр	Дүнг нь бүртгэх гэж буй хичээлийн нэрийг сонгож нэвтэрч орно.

2.2.1 Хичээлийн дүн бүртгэх

Дүн оруулахаар сонгосон хичээлийн нэр дээр дарахад тухайн ангийн сурагчдын жагсаалт дараах байдалтай гарч ирнэ.



Алхам	Үйл явц	Тайлбар
1.	Анги	Хичээлийн дүнг нь бүртгэх ангийн сонголтууд байна.
2.	Төрөл	• Бага боловсрол -Заавал судлах • Суурь боловсрол – Заавал судлах, Сонгон судлах • Бүрэн дунд боловсрол – Заавал судлах, Сонгон судлах Төрлийн сонголтоос хамаарч хичээлийн жагсаалт гарна. Үүнээс хичээлийг сонгож дүн бүртгэнэ.
3.	Хичээлийн нэр	Хичээлийн дүн бүртгэх хичээлийн нэрийг сонгох.
4.	Суралцагч	Суралцагчийг сонгосон үед хичээлийн дүнг бүртгэх боломжтой учраас бүх суралцагчдийг бүртгэх болон зөвхөн тухайн хичээлийг судласан суралцагчдийг сонгож бүртгэнэ.
5.	Дүн нэмэх	Уг **Дүн нэмэх** товчууд адилхан үйлдэл хийх тул Суралцагчдийг сонгосны дараа дүн нэмэх дарсанаар хичээлийн дүн оруулах цонх гарч ирнэ.
6.	Дүн нэмэх	

*Бүрэн дунд боловсролын түвшинд дүнг оруулахдаа **Сонгон судлах** хичээл төрлийг сонгосон үед тухайн түвшний сонгон үзэх шаардлагатай заавал төрлийн хичээлүүд харагдана.*

2.2.2 Хичээлийн дүн хадгалах/ Дүн илгээх/


ХИЧЭЭЛИЙН ДҮНГИЙН БҮРТГЭЛ | 12-а
Анги
12-р анги
Төрөл
Заавал судлах хичээл
1 Биеийн тамир 12
2 Биологи 12
3 Газар зүй 12
4 Математик 12
5 Монгол бичиг 12
6 Монгол хэл 12
7 Монголын түүх 12
8 Мэдээллийн технологи 12
9 Нийгэм судлал 12
10 Уран зохиол 12
11 Физик 12
12 Хими 12
13 Эрүүл мэнд 12
Уран зохиол 12Заавал судлах
Дүн нэмэх
Хадгалах
Дүн илгээх
Судлагдахуун Уран зохиол
Хичээлийн индекс 1200
Хичээлийн ангилал Ердийн хичээл
Хичээл Уран зохиол 12Заавал
Дүнгийн схем 10-12 ангийн дүнгийн схем
Хичээлийн жил 2017
Суралцагч
Регистр
Дүн
Үнэлгээ
Судалсан хэлбэр
Дүнгийн төлөв
Үйлдэл
85.4
B
Хичээл дүйцүүлэх
Бүртгэсэн
Дүн хасах
74.5
C
Хичээл сонголт
99.1
A+
1
2
3
4
5
6
7

Алхам	Үйл явц	Тайлбар
1.	Анги	Хичээлийн дүнг нь бүртгэх ангийн сонголт харагдана.
2.	Төрөл	• Бага боловсрол -Заавал судлах • Суурь боловсрол – Заавал судлах, Сонгон судлах • Бүрэн дунд боловсрол – Заавал судлах, Сонгон судлах Төрлийг сонгосоноор төрөл тус бүрээр хичээлийн жагсаалт харагдана. Үүнээс хичээлийг сонгож дүн бүртгэнэ.
3.	Хичээл	Дүн оруулах хичээлийг сонгоно.
4.	Дүн*	Бага боловсролын I-III ангийн суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтыг үгэн үнэлгээг Мэдээллийн системд оруулахдаа дараах системийн дугаарлалтын дагуу оруулна уу. ➢ Маш сайн – 5 ➢ Хангалттай – 4 ➢ Сайжирч байгаа – 3 ➢ Анхаарах шаардлагатай - 2 Бусад IV-XII ангийн суралцагчдын дүнг гүйцэтгэлийн хувиар буюу 0-100 -аар дүнг бүртгэнэ.
5.	Судалсан хэлбэр	Судалсан хэлбэрийг Хичээл сонголтоор болон хичээл дүйцүүлэх сонголтын аль нэгийг сонгож бүртгэнэ.
6.	Хадгалах	Уг товч нь зөвхөн хянах үйлдэл бөгөөд хичээлүүдийн дүнгийн мэдээлэл үнэн зөв бөглөгдсөн бол заавал илгээх товч дарж бүртгэнэ.
7.	Дүн илгээх	Уг илгээх үйлдлийг хийж байж сургалтын менежер хичээлийн дүнгүүдийг баталгаажуулах боломжтой болно.

<u>Дүн</u> Монгол Улсын Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 2013 оны 08 -р сарын 16 өдрийн №А/309 тушаалын нэгдүгээр хавсралт ёсоор Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын болон боловсролын чанарын үнэлгээний журам баримтласан.*

2.3 Дүнгийн нэгтгэл /Суралцагчаар/

2. Дүнгийн нэгтгэл /Суралцагчаар/

Тухайн нэг суралцагчийг сонгож судалсан бүх хичээлийг нэг цонхноос бүртгэж болно.

Анхаарах зүйлс: Уг цонх нь хичээлийн жил шилжиж ирсэн суралцагчдын хичээлийн дүнгийн бүртгэл хийх болон зөвхөн тухайн суралцагчтай холбоотой дүнг бүртгэхэд тохиромжтой болно.



Алхам	Үйл явц	Тайлбар
1.	Багшийн эрх	Хичээлийн дүн бүртгэх эрхтэй ангийн багш болон сургалтын менежер системд нэвтрэн орно. Анхаарах зүйлс: Дараах 2, 3, 4, 5-р алхамыг зөвхөн өөрийн хариуцаж буй ангийг сонгож дүн бүртгэж оруулна уу.
2.	Хичээлийн хөтөлбөр сонгох	• Бага боловсролын өдрийн хөтөлбөр • Суурь боловсролын өдрийн хөтөлбөр • Бүрэн дунд боловсролын өдрийн хөтөлбөр
3.	Анги сонгох	• Бага боловсрол /1,2,3,4,5-р анги/ • Суурь боловсрол /6,7,8,9 -р анги/ • Бүрэн дунд боловсрол /10,11,12-р анги/
4.	Бүлэг	Анги сонгоход үүсгэгдсэн бүлэг сонголтоор гарч ирнэ
5.	Хөтөлбөрийн төрөл	Уг тушаал нь хөтөлбөр, бүлэг, анги сонгоход автоматаар харагдана. Жнь: 12-р анги A/311-2+A/275-3+A/61 дугаар бүхий тушаалуудыг дагаж мөрдөж байгаа. Анхаарах зүйлс: Тухайн анги бүлэгт хамаарах зөв хөтөлбөрийн төрлийг сонгосноор суралцагчдийн жагсаалт гарна.
6.	Хичээлийн нэр	Дүнг нь бүртгэх гэж буй хичээлийн нэрийг сонгож нэвтэрч орно.

2.3.1 Хичээлийн дүн бүртгэх


ХИЧЭЭЛИЙН ДҮНГИЙН БҮРТГЭЛ
2301)
1
6
8
9
12-р анги
2
Дүн нэмэх
Хадгалах
Дүн илгээх
Хичээлийн нэр
Төрөл
Дүн
Үнэлгээ
Судалсан хэлбэр
Дүнгийн төлөв
Үйлдэл
1 Биеийн тамир 12 Заавал судлах 99.0 A+ Хичээл сонголт Хянагдаж байгаа Дүн хасах
2 Биологи 12 3 Заавал судлах 4 7 Хичээл сонголт 5 Бүртгэсэн Дүн хасах
3 Газар зүй 12 Заавал судлах Дүн нэмэх
4 Математик 12 Заавал судлах 100.0 A+ Бүртгэсэн Дүн хасах

Алхам	Үйл явц	Тайлбар
1.	Суралцагчийн нэр	Тухайн суралцагчийн овон нэр, регистрийн дугаар харагдана.
2.	Анги	Суралцагчийн хичээлийн дүн бүртгэх **анги** сонгох.
3.	Хичээлийн нэр	Суралцагчийн хичээлийн дүн бүртгэх **хичээлийг** сонгох.
4.	Хичээлийн төрөл	Боловсролын түвшингээс хамааран хичээлүүдийг дараах байдаглаар бүлэглэнэ. • Бага боловсрол -Заавал судлах • Суурь боловсрол – Заавал судлах, Сонгон судлах • Бүрэн дунд боловсрол – Заавал судлах, Сонгон судлах
5.	Судалсан хэлбэр	Хэрвээ тухайн хичээлийн жилийн дүн бүртгэж буй үед **Хичээл сонголт** гэж харагдана. Харин өмнөх хичээлийн дүн бүртгэж буй үед **Нөхөж бүртгэсэн** гэж харагдана.
6.	Дүн нэмэх	Суралцагчийн хичээлийн дүнг бүртгэхийн тулд **Дүн нэмэх** товчоор дүнг бүртгэх боломжтой болно.
7.	Дүн	Бага боловсролын I-III ангийн суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтыг үгэн үнэлгээг Мэдээллийн системд оруулахдаа дараах системийн дугаарлалтын дагуу оруулна уу. ➢ Маш сайн – 5 ➢ Хангалттай – 4 ➢ Сайжирч байгаа – 3 ➢ Анхаарах шаардлагатай - 2 Бусад IV-XII ангийн суралцагчдын дүнг гүйцэтгэлийн хувиар буюу 0-100 -аар дүнг бүртгэнэ.
8.	Дүн хадгалах	Суралцагчийн хичээлийн дүн бүртгэсэн бол дүн хадгалах товчоор зөвхөн бүртгэсэн дүнг харах боломжтой.
9.	Дүн илгээх	Харин суралцагчийн хичээлийн дүн бүртгэж дууссан бол дүн илгээснээр дүнгийн төлөв **хянагдаж байгаа** төлөвт шилжинэ. Сургалтын менежер уг дүнг баталгаажуулсанаар **Батлагдсан** төлөвт шилжинэ.

2.4 Хичээлийн дүнгийн нэгтгэл /Суралцагч, Хичээл/

2.4 Хичээлийн дүнгийн нэгтгэл /Суралцагч, Хичээл/

Уг хичээлийн дүнгийн нэгтгэл цонх нь зөвхөн батлагдсан хичээлийн дүн харагдаж байгаа бөгөөд нэгтгэлийг татаж авах боломжтой юм.



Алхам	Үйл явц	Тайлбар
1.	Дүнгийн нэгтгэл	Уг нэгтгэл нь Суралцагчдын судалсан бүх хичээлийн дүнгийн бүртгэсэн дүнг харуулна.
2.	Экспорт	Тухайн ангийн бүртгэсэн хичээлийн дүнгийн нэгтгэлийг татаж авах боломжтой. Уг татаж авсан файл нь Microsoft excel байна.
3.	Анги	Хичээлийн дүн бүртгэсэн анги тус бүрээр харах боломжтой.
4.	Хичээлийн төрөл	Уг хичээлийн жагсаалт нь заавал болон сонгон судлах хичээлээр бүлэглэж харуулна.
5.	Суралцагчдын нэр	Тухайн багшийн удирдсан ангийн суралцагчдын жагсаалт.
6.	Хичээлийн дүн	Хичээлийн дүн батлагдсан төлөвтэй хичээлийн дүн нэгтгэлээр харагдана.